



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Г Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.7, 49 дүгээр зүйлийн 49.1.4, 49.3 дахь хэсгүүд, компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.22 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 1/4028 дугаар албан бичиг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Арилжааны журам"-ын Хавсралт 1-ийн дараах заалтуутад дор дурдсанаар нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:
  - 1) 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс" гэсний дараа "0.3 хувиар" гэж нэмэлт оруулсугай.
  - 2) 1 дүгээр зүйлийн 1.1.1-1.1.5 дахь заалтуудыг хассугай.
  - 3) 7 дугаар зүйлд "Энэхүү хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө" гэж нэмж оруулсугай.
2. Энэхүү тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, баримтжуулахыг Гүйцэтгэх захирал (Х.Алтай)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү "Арилжааны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо батламжилсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1529010121

**Хавсралт 1.**

**ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС**

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн .. тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

1. МХБ нь харилцагчийн тухайн одрийн үнэт цаас худалдах, худалдан авах хэлцлүүдийн үнийн нийлбэр дүнгээс хамааруулан арилжааны шимтгэлийг дараах байдлаар тооцно. Үүнд:

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

- 1.1 Хоёрдогч зах зээл дээр Хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс 0.3 хувиар;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн .. тоот тогтоолоор нэмэлт оруулсан/*

1.1.1. 100-сая хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.4 хувийн;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

1.1.2. 100-саяас 1 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.38 хувийн;

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

1.1.3. 1 тэрбумаас 10 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.3 хувийн;

1.1.4. 10 тэрбумаас 30 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.2 хувийн;

1.1.5. 30 тэрбумаас дээш төгрөгийн үнийн дүнгээс 0.15 хувийн;

*/Энэ хэсгийг төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн ... тоот тогтоолоор хассан/*

- 1.2 Анхдагч зах зээлд хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх худалдсан талаас арилжааны шимтгэлгүй, худалдан авсан талаас энэхүү хавсралтын 1.1-д заасны дагуу арилжааны шимтгэлийг тооцох ба энэхүү шимтгэлийг үнэт цаас гаргагчаас андеррайтерт хүсэлт гаргасан тохиолдолд үнэт цаасны танилцуулгад тусгасан хэмжээгээр талууд хувь тэнцүүлэн хувааж толж болно.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

---

## АРИЛЖЛАНЫ ЖУРАМ

---

2. Анхдагч зах зээл дээр худалдагсан Засгийн газар, орон нутгийн бондын арилжааны үнийн дүнгээс худалдсан талаас 0.12 хувь, худалдан авсан талаас 0.00875 хувийн,
3. Хоёрдогч зах зээл дээр Засгийн газар, орон нутгийн бонд худалдагч нь шимтгэлгүй үйлчлүүлэх ба харин худалдан авсан талаас 0.00875 хувийн,
4. Анхдагч зах зээл дээр компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдсан талаас 0.1575 хувь, худалдан авсан талаас 0.0175 хувийн,

*/Төлөөлон удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны одрийн 2020/07 тоот тогтоолоор оорчлолт оруулсан./*

5. Хоёрдогч зах зээл дээр компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдагч тал шимтгэлгүй, худалдан авагч талаас 0.0175 хувийн шимтгэлийг тус тус тооцон авна.

*/Төлөөлон удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны одрийн 2020/07 тоот тогтоолоор оорчлолт оруулсан./*

6. Тодорхой этгээдтэй байгуулсан гэрээнд зааснаар шимтгэл, үйлчилгээний хөлсийг тооцон авч болно.

*/Төлөөлон удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны одрийн 2015/06 тоот тогтоолоор оорчлолт оруулсан./*

7. Энэхүү хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ... тоот тогтоолоор иймж оруулсан./*

---